



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 02 сарын 10 өдөр

Дугаар А/79

Ховд

Хөрөнгө төвлөрүүлэх тухай

Монгол улсын Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Ховд аймгийн Онцгой комиссын 2020 оны 02 дугаар сарын 05-ны 05 дугаар шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хүнсний хомсдолоос урьдчилан сэргийлэх зорилгоор аймгийн хэмжээнд махны нөөц бүрдүүлэхэд 300,0 сая төгрөг / гурван зуун сая/ -ийг Хөшөөт хөгжил сангаас санхүүжүүлэхтэй холбоотой МоЭнКо ХХК-иас Дарви, Цэцэг суманд олгогдох 2019 оны 4 дүгээр улирлын 15 хувийн санхүүжилтийг аймгийн Хөшөөт хөгжил санд төвлөрүүлсүгэй.

2.Төвлөрүүлсэн санхүүжилтийг нөөцийн махны үнэ буцаан төвлөрсөн даруйд Дарви, Цэцэг суманд олгохыг Ховд хөшөөт хөгжил сангийн гүйцэтгэх захирал /Т.Мягмардорж/-д үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Т.Жаргалсайхан/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Zax A/79 Ch
02 00348